

ГАЛТ ЗЭВСГИЙН ГЭРЧИЛГЭЭ СУНГУУЛАХ ИРГЭН

Үйлчилгээний төрөл: Галт зэвсгийн гэрчилгээ сунгуулах (иргэн)

Шийдвэрлэх журам: Цагдаагийн албаны тухай хууль, Галт зэвсгийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/75 дугаар тушаалаар баталсан “Галт зэвсгийн гэрчилгээ олгох журам”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-602, 603/ “Галт зэвсгийг бүртгэх, гэрчилгээ олгох”

Хугацаа: Ажлын 10 хоног.

Хүсэлт гаргах хэлбэр: Төрийн үйлчилгээний цахим систем <https://e-mongolia.mn/>-д хандан хүсэлт илгээнэ.

Бүрдүүлэх баримт бичиг:

1. 2*3 хэмжээний зураг 3 хувь /одоо үеийн/
2. Иргэний үнэмлэхний хуулбар. /эсвэл лавлагаа/
3. Оршин суугаа хорооны засаг даргын тодорхойлолт. /эсвэл лавлагаа/
4. Галт зэвсгийн гэрчилгээ эх хувиараа.
5. Галт зэвсэг ашиглахад харшлах өвчин, гэмтэл согоггүйг тодорхойлсон эрүүл мэндийн хуудас. /харьяа дүүргийн эрүүл мэндийн төвөөс А/33 маягт/
6. Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын тодорхойлолт. /Даваа гаригт 14:00-16:00; Пүрэв гаригт 10:00-12:00 цагуудад галт зэвсгийг 2 ширхэг сум, иргэний үнэмлэхний хамт авч очно/
7. Гэрчилгээний үнэ 4800 төгрөг тушаасан баримт. /төрийн сан 100900012038 тоот данс. Хүлээн авагч нь ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн алба/
8. Тэмдэгтийн хураамж 10000 төгрөг тушаасан баримт. / itax.mta.mn цахим хаягаар <https://www.youtube.com/watch?v=AdfO-uOeEpA&t=13s> эсвэл Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст очин код аван дурын банк, киоск төхөөрөмжид тушаана /

Гэрчилгээний загвар: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/75 дугаар тушаалаар баталсан “Галт зэвсгийн гэрчилгээ олгох журам”



Нэг. Бүртгэлийн сери:

..... онд улсад
үйлдвэрлэсэн маркийн
1. Гол төмрийн №:

Замагны №:

Гол төмрийн голчийн хэмжээ, сум:

2. Галт зэвсгийн сумны төрөл, зориулалт:

галт зэвсэг өмчлөхийг зөвшөөрч улсын нэгдсэн
бүртгэлд бүртгэв.
Улсын хилээр орж ирсэн огноо:

..... АЙМАГ, ХОТЫН ЦАГДААГИЙН
ГАЗАР, ХЭЛТСИЙН ДАРГА

..... оны сар өдөр

ЦЕГ: **079250**

- 1 -

Хоёр. ГАЛТ ЗЭВСЭГ ӨМЧЛӨГЧ

Өмчлөгчийн ургийн овог, эцэг
/эх/-ийн нэр, өөрийн нэр
(Байгууллагын нэр)

Зураг
2x2см

РД:

Улсын бүртгэлийн дугаар:

Өмчлөх зориулалт:

Сургалтанд хамрагдсан байдал, гэрчилгээний
дугаар:

Хаяг:

Эрхэлсэн ажил, хуулийн этгээдийн үйл
ажиллагааны чиглэл:

..... АЙМАГ, ХОТЫН ЦАГДААГИЙН
ГАЗАР, ХЭЛТСИЙН ДАРГА

..... оны сар өдөр

Тусгай тэмдэглэл:

- 2 -

Төлбөр: Галт зэвсгийн гэрчилгээний үнэ 4800 төгрөг .

Төлбөр төлөх данс: төрийн сан 100900012038 тоот данс. Хүлээн авагч нь ЦЕГ-ын Санхүү, ар талын алба/

Хураамж: Тэмдэгтийн хураамж 10000 төгрөг.

Хураамж төлөх данс: төрийн сан 100200700941 тоот данс. Хүлээн авагч Чингэлтэй дүүргийн татварын хэлтэс

Зөвшөөрөл олгох, сунгах үндэслэл журам: Галт зэвсгийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Хууль зүйн сайдын 2015 оны А/219 дүгээр тушаалаар батлагдсан “Хураагдсан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг устгах, худалдах, өмчлөгчид буцаан олгох, шилжүүлэх журам”, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар бүлэг. Зөвшөөрөл олгох, сунгах журам

Түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам: Галт зэвсгийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Хууль зүйн сайдын 2015 оны А/219 дүгээр тушаалаар батлагдсан “Хураагдсан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг устгах, худалдах, өмчлөгчид буцаан олгох, шилжүүлэх журам”, Зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар бүлэг. Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

Олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл: Зөвшөөрлийн цахим сан (<https://license.mn>)-д байршуулсан.

Зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар төлөөлөгчийн газар: Зөвшөөрлийн цахим сан (<https://license.mn>)-д байршуулсан.

Зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа: 10 жил

Зөвшөөрөл олгосон байгууллагын нэр: Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төв.

Зөвшөөрөл олгосон байгууллагын хаяг, утасны дугаар: Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хороо 1-р хэсэг хичээнгүй сайд Цэрэндоржийн гудамж Хүсний 50 дугаар дэлгүүрийн өргөтгөлийн байр. Утас: 70191515

Хариуцсан албан тушаалтны нэр, утасны дугаар: Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Б.Гансүх 92114844, цагдаагийн ахмад Н.Төрмөнх 95111062